



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ, ҮР ДҮН, 2024 ОНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

Илтгэгч: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг

Улаанбаатар хот
2023 он





“Аудитын шийдвэрийн
хэрэгжилт, үр нөлөөг тооцох
бодлого, арга зүй” сэдэвт
хэлэлцүүлгийг зохион
байгуулсан.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

- ❖ “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг шинэчлэн боловсруулах.
- ❖ Шийдвэрийн тооноос чанарт илүү анхаарах.
- ❖ Аудитын шийдвэрийн чанарын хяналтыг сайжруулах.
- ❖ Аудитын тайлан, шийдвэрийг олон нийтэд ил тод танилцуулахад хүндрэл бэрхшээлтэй байгаа тул цахим хуудсанд хөгжүүлэлт хийх.
- ❖ Аудитын шийдвэрийг оновчтой гаргах талаар аудитын хуулийн этгээдүүдийг арга зүйгээр хангах.



"Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" илтгэлийн уралдааныг ТАБ-ын нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.

Судалгааны ажлуудаас шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах талаар дараах санал, дүгнэлт гаргасан.

- ❖ Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх арга зүйг тодорхойлох.
- ❖ Аудитын шийдвэрийг ангилан нэгтгэж, мэдээллийн цахим сан үүсгэх аргачлалыг боловсруулах.
- ❖ Шалгагдагч байгууллагын дотоод аудитын нэгжтэй төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд хамтран ажиллах.
- ❖ Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах зорилгоор хууль тогтоомж, журам, заавар, аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах жагсаалтыг боловсруулж, 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөв.



Санхүүгийн тайлангийн аудитын FAS системийн хөгжүүлэлт

Системийн хэрэглээнд хяналт, туршилт хийж, ажлын хэсгээр хүлээн авав.

Цаашид анхаарах асуудал

- ❖ Материаллаг байдлыг тооцоолох, түүвэр хийх, санхүүгийн тайлангийн уялдааг шалгаж, үлдэгдлийг тулган баталгаажуулах, санхүүгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийдэг байхаар нэмж хөгжүүлэх.
- ❖ Аудитын эрсдэл, горим сорил, хууль тогтоомжийн мэдээллийн санг хөгжүүлэх.
- ❖ Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг автоматаар боловсруулах горимтой болгох.
- ❖ Статистик мэдээллийг батлагдсан маягтын дагуу системээр боловсруулж, хянах, нэгтгэх, хөрвүүлэх процессыг сайжруулах, гар ажиллагааг халах.
- ❖ Хяналт-шинжилгээ, үнэлгээний системтэй бүрэн холбох боломжтой эсэхийг судалж хэрэгжүүлэх.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН СИСТЕМ

АУДИТЫН ХУВААРЬ

2022 | Үндэсний аудитын газар | Төсөв захирагчийн ангилал

№	Аудитын код	Аудитын нэр	Тайлант хугацаа	Аудит хийх		ТЕЗ Регистрийн дугаар	ТЕЗ
				Эхлэх огноо	Дуусах огноо		
1	СНАГ-2023/138 НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2023-01-25	2023-03-25	5634766	Зам, тээврийн хөгжлийн сэд
2	СНАГ-2023/139 НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2023-01-25	2023-03-25	5634766	Зам, тээврийн хөгжлийн сэд
3	СНАГ-2023/06 НА-СТА-3ГТС	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2023-03-05	2023-04-25	5634766	Зам, тээврийн хөгжлийн сэд
4	СНАГ-2023/33 НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2023-02-15	2023-04-15	5634766	Зам, тээврийн хөгжлийн сэд
5	СНАГ-2023/16 НА-СТА-ТЕЗ	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2022-09-01	2023-05-25	5043239	Санхүүгийн зохицуулах хорооны дар
6	СНАГ-2023/374 НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн аудит	2022	2023-01-25	2023-05-25	6097456	Үндэсний статистикийн хорооны дар

ХУВААРЬ
ТАЙЛАН
БОДИТ ЦАГ
САНХҮҮ БИЕЛЭЛТ
ФАЙЛЫН САН
ТУСЛАМЖ



Гүйцэтгэл, нийцлийн аудитын цахим системийн хөгжүүлэлт

Системийн бодлогын даалгаврыг боловсруулсан.



Гүйцэтгэлийн аудитын аргачлалд суурилан
тодорхойлж, системийн цонхны зураглалын
хөгжүүлэлтийг хийж эхлэв.




Системийг туршилтаар нэвтрүүлж, хэрэглэгчдийн
саналын дагуу сайжруулалт хийв.



Систем ашиглалтын сургалтыг зохион байгуулав.



Ажлын хэсэг системийг хүлээн авсан.





Санхүү-нийцлийн аудитын газар болон Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрууд нь 2019-2022 онд өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулсан байна.

1

Шалгагдагч байгууллагууд аудитаас өгсөн зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө боловсруулдаггүйд анхаарах.

2

Төрийн аудитын байгууллагаас зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хангуулах журмыг боловсруулах.

3

Аудитаар өгөх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн төслийг боловсруулах үе шатны чанарын хяналтыг сайжруулах.

4

Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн хийгдэх үед аудитын шийдвэрүүдийг холбогдох албан тушаалтанд хариуцуулах.



Хугацаа хэтэрсэн аудитын шийдвэрийг судалж, хариу арга хэмжээ авах



Аудитын шийдвэрийн их өгөгдлийг бүрдүүлэх зорилгоор аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудын 2019-2022 онуудад хэрэгжүүлсэн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн.



Төрийн аудитын байгууллагаас 3-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн нийт **316 шийдвэр** байгаа бөгөөд үүний **47 хувь** буюу **149 шийдвэр нь 5-аас дээш жилээр хугацаа хэтэрчээ.**



Жилийн зорилтын хэрэгжилтийг хангуулах, аудитын чанарыг сайжруулах зорилгоор Аудитын зөвлөлийн хурлыг зохион байгуулж хуралдууллаа.

Аудитын зөвлөл 2023 онд нийт 14 удаа хуралдаж 34 асуудал хэлэлцсэн бөгөөд үүнээс давхардсан тоогоор 15 аймгийн 16 тайланг хэлэлцэж, дараах асуудлаар санал, зөвлөмж гаргаж ажилласан.

- ❖ Аудитын үр дүнг зорилго зорилттой уялдуулан нийцүүлэх.
- ❖ Тайлангийн загвар, бичвэр, найруулгыг сайжруулах.
- ❖ Хөндлөнгийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ боловсруулалт хийхгүй аудитын тайланд тусгахгүй байх.
- ❖ Нэгдсэн удирдамжаар болон адил сэдвээр гүйцэтгэж буй аудитад аймгууд харилцан мэдээлэл солилцож байх.
- ❖ Гүйцэтгэж буй аудитын төрлөөс шалтгаалж тухайн аудитын стандарт, арга зүйг мөрдөж ажиллахгүй байна.
- ❖ Үе шатны чанарын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.
- ❖ Аудитын тайлан баталгаажуулах тушаалын бүрдлийг хангахгүй байна.
- ❖ Акт, албан шаардлагын журмыг мөрдөж ажиллахгүй байна.
- ❖ Аудитын тайлангийн дүгнэлтүүд илрүүлэлтийн шинж чанартай, нөхцөл байдал дурдсан, нуршуу, ойлгомжгүй, үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлтийг тодорхойлохгүй байна.
- ❖ Аудитаар өгч буй зөвлөмж ойлгомжгүй, хэрэгжилтийг хэрхэн хангуулах нь тодорхойгүй, үнэлэх боломжгүй, нуршуу, тулган шаардсан, бусдын үйл ажиллагааг шууд заасан хэлбэртэй байна.



Аудитын шийдвэрийн үр дүнг
олон нийтэд мэдээлэх ажлыг
хэрэгжүүлсэн байна.



"Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэсэн аудитын дүгнэлт, үр дүнгийн талаар **иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх**, ажлыг гүйцэтгэж байна.



Аудитын үр дүнгийн талаар **хэлэлцүүлэг нэвтрүүлэгт 12 удаа, телевизэд 43, сайтад 14, өдөр тутмын 3 сонинд тус тус мэдээлсэн** байна.



News.mn сайттай хамтарч **"Аудитын цаг"** хөтөлбөрийг **санаачлан хэрэгжүүлсэн** байна.



ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРААС ЖИЛИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ



Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Булган аймаг дахь болон Нийслэл дэх төрийн аудитын газрын аудитын шийдвэр гаргалт, **хэрэгжилтийг хүлээн авах, үнэлэх, хянах, бүртгэх, баримтжуулах үйл явцад тогтолцооны түвшинд чанарын баталгаажуулалт хийсэн.**



Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг **ил тод, үр нөлөөтэй тайлагнасан эсэхэд улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.**



ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД

Жилийн зорилтын хүрээнд төлөвлөсөн дараах арга хэмжээг 2024 онд гүйцээн хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох бодлого, арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох журам, зааварт өөрчлөлт оруулах;



Аудитад ашиглаж буй цахим системд шийдвэрийн хэрэгжилтийн бүртгэл, тайлагналтай холбоотой сайжруулалт хийх



Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудад гүйцэтгэлийн аудитын талаар сургалтыг зохион байгуулах, бодлого арга зүйгээр хангах



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ



Зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нийт 31 арга хэмжээг тусгасан бөгөөд дунджаар **90.1 хувийн хэрэгжилттэй** байна.

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах **хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орсон**, өмнөх онуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд **зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн**, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг цахимаар хүлээн авч боловсруулах ажлын эхлэлийг тавьсан зэргээр жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн голлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.





Төрийн аудитын байгууллага 2023 онд дараах аудитыг хийж гүйцэтгэсэн байна.





Аудитаас бий болсон үр өгөөж





Аудитаар өгөгдсөн шийдвэрүүд






Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийг боловсруулж, баталсан.

Ерөнхий чиглэлийн зорилго:

- ❖ Аудит хийх журмыг хэрэгжүүлэх, анхаарал татсан эрсдэл бүхий асуудалд чиглүүлэх.
- ❖ Аудитын үр дүнг нэгтгэн харилцагч талуудад танилцуулах.





Засгийн газрын үйл ажиллагаанд болон эрх зүйн хувьд дараах өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн байна.



“Төсвийн зарлага тэлэх бодлого” хэрэгжиж эхэлсэн

Төсвийн ерөнхийлөн захирагчдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт өөрчлөлт орсон



Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журмыг баталсан

“Аккруэл суурьт Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн





Ерөнхий чиглэлд дараах асуудлыг анхаарч үзэхээр тусгасан болно.

- ❖ Анхаарал татсан, тулгамдаж буй болон эрсдэл бүхий асуудлыг тодорхойлох;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн өөрчлөлтийн тайланд гарсан томоохон өөрчлөлтүүдийн шалтгааныг тодруулах;
- ❖ Байгууллагын эзэмшил /өмчлөл/-д байгаа газрын гэрчилгээг кадастрын зурагтай тулган баталгаажуулах, эзэмшил /өмчлөл/-ийн газраас хувийн болон төрийн бус байгууллагад аливаа хэлбэрээр шилжүүлэх, ашиглуулах, ажилчдын орон сууц бариулах зэрэг шийдвэр гаргасан эсэхийг хянах;
- ❖ Боловсрол, эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд хийгдэж буй төсвийн санхүүжилтийн хуваарилалт төсвийн зарчимд нийцэж байгаа эсэхийг цөөн хүн амтай сумдад судлах;
- ❖ Төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, түүний үр дүн, хөрөнгийн бүртгэл;
- ❖ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгасан эсэх;



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠶᠢ
ᠠᠤᠳᠢᠲᠢᠶᠢᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.